



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 1/1134

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5а, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, 14.2.2, 14.2.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, 58 дугаар зүйлийн 58.2.20, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны "Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн жагсаалт батлах тухай" 02, "Аймгийн 2020 оны төсөв батлах тухай" 2019 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн байгалийн болон түүх, соёлын дурсгалт газруудын тухай өгүүлсэн "Хаадын тамгат нутаг Хан Хэнтий" номыг хэвлүүлэх ажилд зориулж 10000000 /Арван сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Чингис хаан брэнд" дэд хөтөлбөрийн/ зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгыг газар /Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ

231010600